

ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ "ДАШИНЧИЛЭНГИЙН ХӨГЖИЛ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2025.12.10.

№	ЗДҮАХ-т тусгагдсан үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	НХХ 2025-2028 (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2025 он		Биелэлт		Б-га TAX
								Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)	Биелэлт	Хувь	
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО												
1.1.ЭРҮҮЛ МЭНД:												
1.1.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.												
1	1.1.1.1. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	1.1.1.1.1. Заавал хийх дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	2024-2028	УТ, ОНТ	-	Хамрагдалтын хувь	95.6%	96%	-	Товлолт дархлаажуулалтад 404 хүүхэд хамруулахаас саа 74, тавт 74, пэв 110, УГУ 105, а гепатит 94, тарьдаг саа 30, сахуу татран 78, ХПВ 76, нийт товлотт дархлаажуулалтад давхардсан тоогоор 641 хүүхэд хамрагдаж, хамрагдалтын хувь 100%-тай байна. Хүний папиллма вирусын вакцинд 11 насны 76 хүүхэд хамрагдахаас 76 хүүхдийг хамруулж, хамрагдалтын эзлэх хувь 100%-тай байна.	100.0	ЭМТ
2		1.1.1.1.2.Хорт зуршил, буруу хооллолт, хөдөлгөөний хомсдол зэрэг анхдагч хүчин зүйлийг бууруулах, мэдээлэл, сургалт сурталчилгааны хамрах хүрээг нэмэгдүүлэх.	2024-2025	УТ, ОНТ	6.0	Хамрагдалтын хувь	-	30%	1.5	ЕБС-ийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлтэй хамтран дунд, ахлах ангийн сурагчдын дунд “Мансууруулах сэтгэц нөлөөт эмийн хор хөнөөл”, “Өсвөр насны эрүүл мэнд”, “Электрон болон утаат тамхи, согтууруулах ундааны хор нөлөө” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад давхардсан тоогоор 256 сурагч хамрагдсан. “Идэвхтэй алхалтад цаг гаргая” биеийн тамырын арга хэмжээний хүрээнд видео контент, мэдээ мэдээллийг сумын цахим хуудсад нийтэлж, иргэд сурталчлах ажлыг зохион байгуулан, аянд идэвхтэй хамрагдсан иргэдийг ЭМТ-өөс урамшуулсан. Мөн иргэдэд “Архи, тамхины хор хөнөөл”, “Давсны хэрэглээг бууруулая”, “Дасгал хөдөлгөөнд цаг гаргая”сэдэвт гарын авлагыг бэлтгэж, нийт 1200 иргэнд тараан зөвлөгөө өгсөн.	82.0	ЭМТ
3		1.1.1.1.3.Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх.	2024-2028	УТ, ОНТ	8.0	Хамрагдалтын хувь	43%	55%	2.0	Эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих нийт 1911 иргэнээс, 726 иргэн хамрагдаж, хамрагдалтын хувь 38 хувьтай байна.	69.0	ЭМТ
4		1.1.1.1.4.Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, хандлага өөрчлөх, ХБӨ, хорт хавдраас урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах.	2024-2028	УТ, ОНТ	4.0	зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан иргэдийн хувь	30%	35%	1.0	ЭМГ-ын даргын А/13 тоот тушаалаар батлагдсан нэрэмжит сар, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай ажлын хүрээнд цахимаар 356 мэдээллийг 5750 иргэнд хүргэж, 56 сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 9850 иргэнийг мэдээллээр хангасан байна. Дашинчилэн эрүүл мэндийн төв фэйсбүүк хуудсаар дамжуулан “Амны хөндийн эрүүл ахуй” сэдвээр Б.Оюундамба, “Шинжилгээ өгөхөд анхаарах зүйлс” сэдвээр лаборант Д.Цогзолмаа, “Гарын эрүүл ахуй”сэдвээр жолооч П.Пүрэвсүрэн, “А амин дэм уухын ач холбогдол” сэдвээр статистикч Н.Ариунцэцэг, “Хүнсний бүтээгдэхүүн худалдан авахад анхаарах нь” сэдвээр сургалтын арга зүйч Д.Ариунтунгалаг ,“Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлье” сэдвээр ахлах сувилагч Б.Сугармаа, “Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлье” сэдвээр эх баригч Н.Отгончимэг, “Цаг гаргая” аян, “Шүдээ тогтмол угаацгаая” уриалга, “Нийгмийн эрүүл мэндийг дэмжье”, “Тамхины хор хөнөөл”, “ХДХВ/ДОХ-ын талаар та мэдэх үү” зэрэг сэдвээр өсвөрийн эмч клубын сурагчид тус тус нийт 11 богино хэмжээний бичлэгийг хийж, 781 иргэнд хүргэсэн байна.	90.0	ЭМТ
5	1.1.1.1.5.Эрүүл мэндийн сайн дурын туслагч нарыг бэлтгэх, сургалтад хамруулах	2024-2028	УТ, ОНТ	2.0	Бэлтгэгдсэн СДТ-ын тоо	-	1	0.5	0.5	100	ЭМТ	

6		1.1.1.2.1.Аймаг, сумын Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг зохион байгуулах.	2024-2028	УТ, ОНТ	4.0	Хамрагдсан иргэдийн хувь	15%	20%	1.0	Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нартай хамтран эрт илрүүлэх үзлэгийг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 298 иргэн хамрагдсан. Мөн 2025 оны 05 дугаар сард аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нартай хамтран эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эрсдэлт бүлгийн 136 иргэнийг хамруулсан. Эрт илрүүлэг үзлэгээр өөрчлөлт илэрсэн 4 иргэнийг Булган аймгийн нэгдсэн эмнэлэгт онош тодруулахаар шилжүүлсэн. 2025 оны 11 дүгээр сард аймгийн нэгдсэн эмнэлгээс Хиймэл оюун ухаанд суурилсан рентген аппаратаар сүрьеэ илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, үзлэгт 162 иргэн хамрагдаж, өөрчлөлттэй гарсан 16 иргэнээс цэрний шинжилгээ, 12 иргэнээс сүрьеэгийн сорилын шинжилгээг авч, сорил өөрчлөлттэй гарсан 6 иргэнийг аймгийн нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн диспансерт онош тодруулахаар хүргүүлэхээр ажиллаж байна.	85.0	ЭМТ
7	1.1.1.2. Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулна.	1.1.1.2.2.Хүн амын дунд зонхилон тохиолдох ХБӨ-ний асуумж судалгааг авч, чихрийн шижин, артерийн даралт ихсэх, зүрх судасны эмгэгийг эрт илрүүлж, зохистой түвшинд хянах	2024-2028	УТ, ОНТ	-	Хамрагдсан иргэдийн хувь	50%	55%	-	2025 оны байдлаар эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж байгаа нийт хүн амын үзлэгийн 10 хувь буюу 714 иргэн амьсгалын замын өвчлөл, 14.5 хувь буюу 1038 иргэн зүрх судасны өвчлөл, 0.7 хувь буюу 52 иргэн осол гэмтэл, 0.08 хувь буюу 6 хүн халдварт өвчний тохиолдлоор эрүүл мэндийн үйлчилгээ авсан байна. Халдварт өвчний эрт илрүүлгийн үзлэг артерийн гипертензийн үзлэгт 1854 иргэн хамрагдахаас 1854 иргэн хамрагдаж, хамрагдалтын хувь 100%, чихрийн шижин хэв шинжийн үзлэгт 1265 иргэн хамрагдахаас 1265 иргэн хамрагдаж, хамрагдалтын хувь 100%, хөхний үзлэгт 497 эмэгтэй хамрагдахаас 505 хамрагдаж, хамрагдалтын хувь 100.1%, умайн хүзүүний үзлэгт 162 эмэгтэй хамрагдахаас 150 эмэгтэй хамрагдаж, хамрагдалтын хувь 92.5%-тай тус тус явагдаж байна. Зүрх судасны өвчлөлттэй 35 иргэн хяналтад байгаагаас энэ онд 5 иргэнд зүрх судасны эмгэг оношлогдсон. Зүрхний цочмог шигдээсээр 2 иргэн, тархины цусан харвалтаар 1 иргэн оношлогдон дээд шатны эмнэлэгт мэс заслын эмчилгээнд хамрагдсан.	90.0	ЭМТ
8	1.1.1.3. Өвчлөл нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлсийн тархалтыг тогтоож, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	1.1.1.3.1.Өвчлөл нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар судалгаа хийж, судалгаа дүгнэлтэд үндэслэн нотолгоонд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх	2024-2028	УТ, ОНТ	-	Зохион байгуулсан судалгаа, арга хэмжээний тоо, төлөвлөгөөний хэрэгжилт	50%	55%	-	2025 онд “Ходоод, улаан хоолойн хавдрын эрсдлийг үнэлэх асуумж”-аар 100 иргэнээс судалгааг авч үнэлсэн. Үнэлгээнээс харахад 30% эрсдэл багатай, 28% дунд эрсдэлтэй, 42% өндөр эрсдэлтэй гарч байна. Насны хувьд авч үзвэл 50-59 насанд ходоодны архаг үрэвсэл, ходоод, 12 нугалаа гэдэсний шарх илэрч байна.	85.0	ЭМТ
1.1.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.												
9		1.1.2.1.1.ЭМТ-ийн ашиглалтад оруулах барилгыг	2025	Төсөл хөтөлбөр	5.6 тэрбум	Барилга, байгууламжийн тоо	ЭМТ-ийн шинэ барилгын ажлын гүйцэтгэл 60%-тай явагдаж байна	100%	5.6 тэр бум	Азийн хөгжлийн банкны 5.6 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 ортой жишиг эрүүл мэндийн төвийн барилга баригдаж, 2025 он 11 дүгээр сард нээлтээ хийсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн 13.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэ эрүүл мэндийн төвийн барилгыг хашаажуулах ажил, 5.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн төвийн гадна гэрэлтүүлгийн ажил, 0.8 сая төгрөгөөр бетонон тулгуурыг зөөвөрлөх ажил, 2.5 сая төгрөгийн хөрөнгөөр шилэн хаалга, хананд хуулга наах ажил тус тус хийгдсэн.	100.0	ЭМТ

10	1.1.2.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, барилга байгууламжид өргөтгөл хийх, стандартын шаардлагад нийцүүлнэ	1.1.2.1.2.ЭМТ-д стандартын шаардлага хангасан моргийн барилгыг шинээр барих	2024-2028	УТ, ОНТ	730.0	барилгын ажлын явц	-	-	Эрүүл мэндийн төв нь 760 сая төгрөгийн өртөг бүхий морг болон 2 автомашины грашийн барилгын зураг төсвийг шинээр хийлгэсэн.		ЭМТ	
11		1.1.2.1.3.ЭМТ-ийн барилгыг цэвэр бохир усны төвлөрсөн төв шугамд холбох	2024-2028	УТ, ОНТ	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	-	ЭМТ-ийн барилга цэвэр, бохир усны төвлөрсөн төв шугамд холбогдоогүй байгаа. Сумын цэвэр усны шугам ЭМТ-ийн хашаанд хүрсэн, холбогдох ажил 2026 онд хийгдэнэ.	65.0	ЭМТ	
12		1.1.2.1.4.ЭМТ-ийг шаардлагатай төхөөрөмжөөр бүрэн хангах	2025	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр	630.0	Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт	одоогоор нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 89%-тай	90%	600.0	Орон нутгийн хөгжлийн сангийн 7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар иммунологийн автомат анализатор, 3.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар өндөр, жин хэмжигч, сувилагчийн тэргэнцэр, ханын кварцын гэрэл, хүлээлгийн сандал зэрэг тоног төхөөрөмжийг худалдан авсан. Улаанбаатар хот дах нутгийн зөвлөлөөс 5 сая төгрөгийн өртөг бүхий компьютер, принтерийг хүлээлгэн өгсөн. Байгууллагын төсвийн 29.3 сая төгрөгийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлын худалдан авалтыг хийгээд байна. Иргэн Д.Ариун-Одын хандиваар 6.6 сая төгрөгийн үнэ бүхий тавилга хэрэгслээр ажилчдын амрах өрөөг тохижуулсан. ЭБИЭМТҮХСХОХ -I үе шат төслийн хүрээнд 70 нэр төрлийн 626,7 сая төгрөгийн өртөг бүхий 115 ширхэг тоног төхөөрөмж суурилулагдсан. Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалт 98%-тай байна.	100.0	ЭМТ
13		1.1.2.1.5.ЭМТ-н барилгыг бүрэн камержуулж аюулгүй байдлыг хангах	2024-2026	ОНТ	-	-	-	-	-	Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд эмнэлгийн байрыг бүрэн камержуулсан. Шинэ эмнэлгийн байранд дотор 8, гадна 3 камерыг шинээр суурилуулсан.	100.0	ЭМТ
14	1.1.2.2. Сумын хэмжээнд хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон өвчлөлийг бууруулах ажлыг зохион байгуулж, Засгийн газар, аймгаас хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүдийг орон	1.1.2.2.1.Эрүүл шүд -Эрүүл хүүхэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, шүдний урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, өвчлөлийг бууруулах	2024-2028	УТ, ОНТ	4.0	Өвчлөлтийн бууралтын хувь	0-16 насны хүүхдийн 70% нь шүдний цооролттой,	65%	1.0	2025 онд 2-18 насны 974 хүүхдийг шүдний үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 294 хүүхдийг хамруулж, эмчлэн эрүүлжүүлэлтийн хувь 30,2% байна. Амны хөндийн эрүүл мэндийг оношлох үзлэгийг 2025 оны байдлаар 5 удаа зохион байгуулж, нийт сурагчдын 90 хувийг хамруулсан. Амны хөндийн үзлэгээр шүдний өвчлөл, гажиг илэрсэн хүүхдүүдийг эмчлүүлэх, зөв дадал хэвшилд сургах ажлыг эцэг эхтэй нь хамтран хэрэгжүүлж байна. Сургууль, цэцэрлэгийн хувьд шүд угаах орчин нөхцлийг бүрдүүлсэн. “Эрүүл шүд, цэвэр гар” аяныг өрнүүлж, сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдыг “Шүд угаах цаг”-тай болгож, шүд угаах ажил хэвшсэн. Сувгийн эмчилгээг 32 хүүхдэд, ломбо 97 хүүхдэд, шүд авах үйлчилгээг 45 хүүхдэд үзүүлсэн байна.	85.0	ЭМТ
15		1.1.2.2.2.Шинэ болон дахин сэргэж байгаа өвчнөөс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах	2024-2028	УТ, ОНТ	20.0	Бэлэн байдал хангалтын хувь	халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын нөөц 65%-тай	68%	5.0	Шинэ болон дахин сэргэж буй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 51 сая төгрөгийн өртөг бүхий шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, 7.2 сая төгрөгийн оношлуур, 1.7 сая төгрөгийн хамгаалах өмсгөлийн татан авалт хийсэн. Бэлэн байдлын нөөцийн хангалтыг нэмэгдүүлж эм бэлдмэл, хамгаалах нэг удаагийн хэрэгсэл, оношлуурын 2 сарын нөөцийг бүрдүүлсэн.	100.0	ЭМТ

16	нутагт хэрэгжүүлнэ.	1.1.2.2.3.Сүрьеэ, тэмбүү өвчнийг эрт илрүүлэх үзлэг шинжилгээг зохион байгуулж, өвчтэй илэрсэн иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах.	2024-2028	УТ, ОНТ	2.0	Илрүүлэгт хамрагдсан иргэдийн тоо	сүрьеэ , тэмбүү өвчний эрт илрүүлэх зорилтот бүлгийн иргэдийн хамрагдалт 38%	45%	0.5	Сүрьеэгийн хавьтал болон эрсдэлт бүлгийн 136 иргэдийг сүрьеэгийн эмчийн үзлэг, цээжний рентген шинжилгээнд хамруулсан. 2025 оны 11 дүгээр сард аймгийн нэгдсэн эмнэлгээс Хиймэл оюун ухаанд суурилсан рентген аппаратаар сүрьеэ илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, үзлэгт 162 иргэн хамрагдаж, өөрчлөлттэй гарсан 16 иргэнээс цэрний шинжилгээ, 12 иргэнээс сүрьеэгийн сорилын шинжилгээ авч, сорил өөрчлөлттэй гарсан 6 иргэнийг аймгийн нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн диспансерт онош тодруулахаар хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Дох тэмбүү илрүүлэх шинжилгээнд нийт 54 иргэнийг хамруулсан.	85.0	ЭМТ
17		1.1.2.2.4."Эрүүл Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2024-2028	УТ, ОНТ	4.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 71.8%-тай байна	70%	1.0	"Эрүүл Булган" хөтөлбөрийн хүрээнд 4 зорилт, 32 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 81 хувьтай байна.	81.0	ЭМТ
18	1.1.2.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, худалдан авалт, ил тод байдлыг хангуулах замаар иргэдийн эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.	1.1.2.3.1.Эмийн хэрэглээг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.	2024-2028	УТ, ОНТ	0.4	Сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо	-	2, 25%	0.1	"Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь", "Эмийн гаж нөлөө, эрсдлээс сэргийлэх" сэдэвт сургалтыг 2 удаа зохион байгуулсан.	80.0	ЭМТ
		1.1.2.3.2.ЭМТ-д шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах үйл ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийх, эмийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах	2024-2029	УТ, ОНТ	-	Хяналт шалгалтын тоо	1 удаа зохион байгуулсан	2	-	2025 онд 1.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг цахимаар 5 удаагийн худалдан авалт хийсэн.	90.0	ЭМТ
1.1.3.Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулна.												
19	1.1.3.1. Эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, гадаад, дотоодод сургах, туршлага судлуулах, шинэ залуу боловсон хүчнийг бэлтгэх замаар эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ.	1.1.3.1.1.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	2024-2028	УТ, ОНТ	4.0	Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	1	1	1.0	Эрүүл мэндийн төвийн 1 сувилагчийг Улсын 1 дүгээр төв эмнэлэгт эрчимт эмчилгээний сувилагчаар мэргэшүүлэх сургалтад хамруулж, сургалтад хамрагдах хугацааны цалинг олгосон.	100.0	ЭМТ
		1.1.3.1.2.эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг лавлагаа шатлалын эмнэлэг болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад богино хугацаагаар сургалтад хамруулж, туршлага судлуулах	2024-2028	УТ, ОНТ	4.0	Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	1	1	1.0	Тайлант хугацаанд 16 эмч, мэргэжилтэн, давтан сургалтад 10 эмч мэргэжилтнүүд хамрагдсан байна.	95.0	ЭМТ
20	1.1.3.2. Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг орон байраар хангах, нийгмийн баталгааг сайжруулах, орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох дэмжлэг, урамшууллыг нэмэгдүүлнэ.	1.1.3.2.1.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад орон байрны дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг дэмжих	2024-2028	УТ, ОНТ	60.0	Хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	1	2	30.0	Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг орон байраар хангах ажлын хүрээнд ОНХС-ийн 30 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зөөврийн орон сууцыг худалдан авч, эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгсөн. 1 их эмчийг орон байраар хангасан.	95.0	ЭМТ
		1.1.3.2.2.Хууль тогтоомжийн хүрээнд заагдсан бусад дэмжлэг урамшууллыг бүрэн олгох	2024-2028	УТ, ОНТ	-	Хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь	90%	92%	-	Эрүүл мэндийн төвийн 24 албан хаагчдад Засгийн газраас баталсан журмын дагуу улирлын урамшуулалыг олгосон.	100.0	ЭМТ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗОРИЛТЫН ДУНДАЖ											89.9	
1.2.БОЛОВСРОЛ												
1.2.1.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэн, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бий болгоно.												
21		1.2.1.1.1.Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах цахим танхимын тоог нэмэгдүүлэх	2025-2028	ОНТ	80.0	Танхимын тоо	0	1	80.0	Орон нутгийн хөгжлийн сангийн 80 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 хүүхдийн суудалтай, англи хэлний лингафоны танхимыг шинээр байгуулсан. Pearson англи хэлний сургалтын цогц хөтөлбөрийн төлбөрт 7.9 сая төгрөгийг төлсөн.	100.0	ЕБС
22		1.2.1.1.2.Номын сангийн ном, сурах бичгийн тоог нэмэгдүүлэх, орчин нөхцлийг сайжруулах	2025-2028	ОНТ	52.4	ном сурах бичгийн баяжилтын тоо	номын тоо-845258	100	12.2	2025 онд ЕБС-ийн номын сангийн фондод 805 ширхэг сурах бичгийн хангалт хийгдсэн	75.0	ЕБС

23	1.2.1.1.Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрт шаардлагатай хөрөнгө оруулалтыг тусгуулж, багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ.	1.2.1.1.3.ЕБС, Цэцэрлэгт стандартын шаардлага хангасан хичээлийн лаборатори, кабинет байгуулах	2025	УТ, ОНТ	20.0	Кабинетийн тоо	0	1	5.0	ЕБС-ийн сурагчдын эцэг, эхийн дэмжлэг болон байгууллагын төсвийн хөрөнгөөр биологийн кабинет байгуулах ажил хийгдсэн. Тус ажилд 5,5 сая төгрөгийг зарцуулсан.	85.0	ЕБС, цэцэрлэг
24		1.2.1.1.4.ЕБС, цэцэрлэгийн Сандартын шаардлага хангасан гал тогооны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	2025-2028	ОНТ	20.0	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	60%	-	-	ЕБС-ийн нөхөн хангалтын зардлаас 5 сая төгрөгөөр тасалгааны 2ш хүлэмж, БШУЯ-ны тэгш суралцах боломжийг бүрдүүлэх төслийн хүрээнд 8.3 сая төгрөгийн өртөг бүхий аяга таваг угаачгийг шинээр авсан.	80.0	ЕБС, цэцэрлэг
25		1.2.1.1.5.Хүүхдийн өөрийн оролцооны байгууллагуудын хүүхэд хөгжлийн өрөө, клубын тоог нэмэгдүүлэх, тохижуулах	2025-2028	УТ, ОНТ	12.0	Клубын тоо	6	7	3.0	2025-2026 оны хичээлийн жилд хүүхдийн өөрөө удирдах 7 клуб үйл ажиллагаа явуулж байна. Нийгмийн ажилтны өрөөнд хүүхдийн өөрөө удирдах зөвлөлийн шаардлага хэрэгсэл, мэдээллийн самбарыг байршуулж, өрөөг тохижуулсан.	80.0	ЕБС, цэцэрлэг
26		1.2.1.1.6."Шүд угаах цаг" үйл ажиллагааг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх	2025-2028	УТ, ОНТ	4.0	угаалтуурын тоо	25	28	1.0	Хүүхдийн биеийн ерөнхий үзлэг, амны хөндийн эрүүл мэндийг оношлох үзлэгийг 2025 оны байдлаар 5 удаа зохион байгуулж, нийт сурагчдын 90 хувийг хамруулсан. Амны хөндийн үзлэгээр шүдний өвчлөл, гажиг илэрсэн хүүхдүүдийг эмчлүүлэх, зөв дадал хэвшилд сургах ажлыг эцэг эхтэй нь хамтран хэрэгжүүлж байна. Сургууль, цэцэрлэгийн хувьд "Эрүүл шүд, цэвэр гар" аяныг өрнүүлж, шүд угаах орчин нөхцлийг бүрдүүлсэн. ЕБС-ийн 1-5 дугаар ангийн сурагчдыг "Шүд угаах цаг"-тай болгож, шүд угаах ажил хэвшсэн.	90.0	ЕБС, цэцэрлэг
27	1.2.1.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн өргөтгөл шинэчлэл, их засварын ажлыг хэрэгжүүлнэ.	1.2.1.2.1.Цэцэрлэгийн 75 хүүхдийн өргөтгөл барилга шинээр барих	2025-2027	УТ, ОНТ	3520.0	ашиглалтад орсон Өргөтөгөл барилга	хүчин чадал 1 дахин хэтэрсэн	Зураг төсөв хийлгэх	20.0	ОНХС-ийн 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн 75 хүүхдийн өргөтгөл барилгын зураг төсвийг "Аслаан" ХХК-иар гүйцэтгүүлж байна.	75.0	Цэцэрлэг
28		1.2.1.2.2.ЕБС хичээлийн 1,2 дугаар завсар хийлгэх	2025-2027	УТ, ОНТ	90.0	Ажлын гүйцэтгэл	-	Үүдний хэсгийг засварлах	50.0	Байгууллагын төсвийн 54 сая төгрөгийн хөрөнгөөр ЕБС-ийн коридорийг засварлах ажил, 160м хашааг шинээр барих ажил, ОНХС-ийн 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар спорт талбайг хашаажуулах ажил тус тус хийгдсэн.	90.0	ЕБС
		1.2.1.2.3.Цэцэрлэгийн барилгад их засвар хийх	2026-2027	УТ, ОНТ	200.0	ашиглалтад орсон Өргөтгөл барилга	хүчин чадал 1 дахин хэтэрсэн	-	-	Цэцэрлэгийн барилгын ариун цэврийн шугам, ангиудын ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуурыг шинэчлэх, цэцэрлэгийн хашааны зүүн талыг шинэчлэх ажлууд хийгдсэн. Тус ажилд 23,8 сая төгрөг зарцуулсан.		Цэцэрлэг
29		1.2.1.3.1.Дотуур байрыг хатуу, зөөлөн эдлэлээр үе шаттайгаар хангах	2025	УТ, ОНТ	20.0	Хүүхдийн тоо	-	150	20.0	Боловсролын ерөнхий газраас шинээр баригдсан дотуур байранд 40.6 сая төгрөгийн өртөг бүхий тавилга, эд хогшлыг хүлээлгэн өгсөн. Мөн сумын ОНХС-ийн 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн зөөлөн эдлэлийг шинэчлэсэн.	100.0	ЕБС

30	1.2.1.3. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хөгжил, хамгааллын орчинг сайжруулж, хүүхдийн сурч, хөгжих тэгш эрхийг хангана.	1.2.1.3.2.Хүүхдийн авьяасыг нээн илэрүүлж, хөгжүүлэх дугуйлангуудыг тогтмолжуулан, аймаг улсын уралдаанд оролцох массыг нэмэгдүүлэнэ.	2025-2028	ОНТ		тогтмол ажилладаг дугуйлан, уралдаан оролцож амжилт гаргасан хүүхдийн тоо	СӨББ дахь дугуйлан, 1-2 уралдаанд	4 дугуйланг сумын СТ тэй хамтран	-	Хүүхдийн авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх чиглэлээр волейбол, үндэсний бөх, самбо жудо, мини волейбол гэсэн 4 төрлийн биеийн тамирын секц хичээллэж 80 сурагч, судлагдахууны чиглэлээр 10 дугуйлан хичээллэж 240 сурагч, давхардсан тоогоор дугуйлан, секцэд 320 сурагч хамрагдаж байна. Хөтлөгчийн дугуйлангийн хүүхдүүд "Бяцхан ертөнц" танин мэдэхүйн цуврал нэвтрүүлэг, "Хүүхдээ сонсьё", "Үеийн мэдээ, зөвлөгөө", "Цаг агаар", "Эрүүл мэндийн булан" зэрэг агуулгаар нэвтрүүлэг бэлтгэн цахим хуудас, группүүдэд байршуулан хүргэж байна. 2025 оны "Үндэсний бөхийн өсвөр үе"-ийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд ЕБС-ийн баг, тамирчид амжилттай оролцож, 14-15 насны ангилалд 10а ангийн сурагч М.Өлзий-Учрал 2-р байр, мөнгөн медаль, 16 насны ангилалд 11б ангийн сурагч Г.Гантулга 3-р байр, хүрэл медаль тус тус хүртэж, багийн дүнгээр 4-р байранд шалгарсан. ЕБС-ийн сурагч Ц.Базаррагчаа нь модон барилдааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, хүрэл медаль хүртсэн. 2024-2025 оны хичээлийн жилд "Бага боловсрол бидний ирээдүй" уриан дор бага боловсролын анги хамт олны масс олимпиад зохион байгуулагдаж, аймгийн хэмжээнд нийт II-V ангийн 257 бүлэг, 6554 суралцагч оролцож, 2 дугаар ангийн төрөлд ЕБС-ийн Д.Март багштай 2а анги 2 дугаар байранд орсон амжилтыг гаргасан.	95	ЕБС, цэцэрлэг
31		1.2.1.3.3.Туршилтын талбай байгуулж, сургалтад ашиглах	2025	БТ, ТХ		сургалтад зориулсан талбай	байхгүй	-	-	ЕБС нь байгууллагын төсвийн 2.5 сая төгрөгийн хөрөнгөөр хүлэмж худалдан авч, хичээлийн туршилтад ашиглаж байна.	70	ЕБС, цэцэрлэг
32		1.2.1.3.4.ЕБС, цэцэрлэгийн сурагчдыг тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана	2025	ОНТ, УТ	20	Тоглоом хэрэглэгдэхүүн хангагдсан бүлэг	хангалт 60%	70%	10.0	Байгууллагын төсвийн хөрөнгө болон эцэг эхийн тусламжтайгаар 6.4 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, ОНХС-ийн 5,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар STEAM сургалтын хэрэглэгдэхүүнийг худалдан авч, сургалтад ашиглаж байна. БШУЯ-ны тэгш боломжийг хүртээх төслийн хүрээнд мэдээлэл зүйн кабинетэд 5 суурин компьютер, 5 нөүтбүүкийг хүлээлгэн өгсөн.	90.0	ЕБС, цэцэрлэг
33		1.2.1.3.5.ЕБС, цэцэрлэгийн 00 өрөө, анги танхимын АЦӨ-г засварлах, ашиглалтыг сайжруулах	2025	ОНТ, УТ	40	Ашиглалтад оруулсан өрөөний тоо	60%	65%	-	Хүүхэд хамгааллын төлөвлөгөөнд тусгагдсан дагуу ариун цэврийн өрөөг засварлах, шинэчлэх ажлыг 100 хувь хийгдсэн.	95	ЕБС, цэцэрлэг
1.2.2.Багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадвар, ёс зүйг дээшлүүлж, боловсон хүчний нөөц, нийгмийн баталгааг хангана.												
34		1.2.2.1.1.Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах танхимын ба танхимын бус сургалтад багш нарын хамруулах, чадваржуулах	2025-2028	ОНТ	2.0	Бэлтгэгдсэн багшийн тоо	2	2	0.5	Сургалтын шинэ хөтөлбөр шинэчлэлийн хүрээнд зохион байгуулсан Үндэсний хэмжээний сургалтад арга зүйч, бүсийн сургалтад 2 багш, аймгийн сургалтуудад нийт багш нараа хамруулан суралцуулсан. Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж багшийг чадваржуулах сургалтад ЕБС-ийн 1 багш хамрагдсан. Ялгаатай хэрэгцээтэй ажиллаж байгаа ЕБС-ийн 2 багш, цэцэрлэгийн 6 багшид сар бүр үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх цалингийн нэмэгдлийг олгож байна.	90.0	ЕБС, цэцэрлэг

35	1.2.2.1. Багш, удирдах ажилтны мэргэжил, арга зүйн тасралтгүй хөгжлийг дэмжиж, суралцагчийн хэрэгцээ шаардлагыг хангасан, чадварлаг багшийг бэлтгэнэ.	1.2.2.1.2.Багш нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, ажлын байран дээрээ тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлэх, шилдэг багш шалгаруулах журмыг боловсруулж, урамшуулах	2025-2028	ОНТ	4.5	Журмын хэрэгжилт	-	-	-	ЕБС-ийн багш нарыг ажлын байран дээрээ тасралтгүй суралцах, хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлэхээр мэргэжлийн багш нарын 7 бүлгийг байгуулж, "Мэргэжлийн багш нарын бүлэг-Манай сургуульд" хэлэлцүүлэг, "Боловсролын шинэчлэлд эцэг эхийн үүрэг, оролцоо" сэдэвт илтгэлийн уралдааныг зэргийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Э.Будмаа ахлагчтай "EDU STEP" баг, Б.Ангарамгаа ахлагчтай "Хамтын хөгжил" бүлгүүдийн үйл ажиллагаа шалгарч, 2 багийн туршлагыг аймгийн Боловсролын газарт хүргүүлсэн. Илтгэлийн уралдаанд М.Бямбасүрэн ахлагчтай баг 1-р байр, Б.Даваасүрэн ахлагчтай баг 2-р байр, Э.Дондог ахлагчтай баг 3-р байр тус тус эзэлсэн байна.	85.0	ЕБС, цэцэрлэг
36		1.2.2.1.3.Багш нарыг дотоод, гадаадад туршлага судлуулах, сургалтад хамруулах, мэргэжил боловсролыг дээшлүүлнэ.	2025-2028	УТ, ОНТ	4.0	Хамрагдсан багшийн эзлэх хувь	45%	50%	1.0	ЕБС-ийн технологийн 3 багшийг Буриад улсад, цэцэрлэгийн арга зүйч, бүлгийн 1 багшийг Дархан-Уул аймагт ажил мэргэжлийн туршлага судлах сургалтад хамруулсан. 2025-2026 оны хичээлийн жилд Булган аймгийн боловсролын газраас ЕБС, цэцэрлэгийн удирдах ажилтны сайн туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх, удирдах ажилтны хамтын ажиллагааг өргөжүүлэх,бэхжүүлэх зорилго бүхий "Удирдах ажилтны солилцоо" арга хэмжээг зохион байгуулж, захирал Ю.Цогмандах 2025.11.24-2025.11.28-ны өдрүүдэд Тэшиг сумын ЕБС дээр ажиллаж, туршлага солилцсон. Мөн ЕБС-ийн технологийн багш Э.Дондог Сайхан суманд 7 хоногийн хугацаатай туршлага солилцох арга хэмжээнд хамрагдсан.	100.0	ЕБС, цэцэрлэг
37	1.2.2.2. Багш, удирдах ажилтны нийгмийн баталгааг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.	1.2.2.2.1.Аймаг, сумын "Төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх, сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх	2025	УТ, ОНТ	20.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	80	82%	5.0	Багшийн хөгжлийн төвийг байгуулахаар нэг ангийг үе шаттайгаар тохижуулах ажил хийгдэж байна. Бага боловсролын багш А. Сүвд-Эрдэнийг Түүх, Нийгмийн ухааны багшаар хөрвүүлэн суралцуулж, дутагдалтай байгаа орон тоог нөхсөн. ЕБС-ийн багш нарыг суралцагч төвтэй, тэгш хамруулах, идэвхтэй сургалтын арга зүй, суралцагчийн үнэлгээний талаарх мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилготой мэргэжил дээшлүүлэх сургалтыг сургалтын менежерүүд нийт 31 багшид зохион байгуулсан. ТАХ-дын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байна. Багш ажилтан нийт 45 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж, 3,426,000 төгрөгийг зарцуусан. Багш нарын ажиллах орчинг сайжруулах зорилгоор 2.1 сая төгрөгийн тавилга эд хогшлыг худалдан авсан.	95.0	ЕБС, цэцэрлэг
38	1.2.2.3. Ёс зүйг эрхэмлэн сахиx, багшийн үнэлэмжийг	1.2.2.3.1.Сургууль, цэцэрлэгийн дэргэдэх ёсзүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааг сайжруулах	2025-2028	УТ		Арга хэмжээний тоо	1	4	-	ЕБС-ийн дэргэдэх ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг улирал бүр хамт олонд тайлагнан ажиллаж байна. Нийслэлийн ёс зүйн хорооноос зохион явуулсан "Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах" сургалтад ёс зүйн дэд хорооны гишүүд хамрагдсан. Сургалтад хамрагдсанаар ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг ашиглах системийн мэдлэгтэй болсон.	95.0	ЕБС, цэцэрлэг

39	нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	1.2.2.3.2.Багш, ажилчдад чиглэсэн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2025	төсөв, АЙМАГ ОНТ	-	Зохион байгуулсан ажлын тоо, хамрагдсан багш ажилчдын хувь, зөрчлийн тоо	70%	4, 75%, бууруулна	-	ТАХ-ын ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр багш, ажилчдад ёс зүйн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 95 багш, ажилчид хамрагдсан. Мөн албан хаагчдын дунд АХА тэмцээнийг зохион байгуулж, ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх мэдээлэл, боршур бэлтгэн тараасан. Байгууллагын ёс зүйн дэд хороо нь нийгмийн ажилтантай хамтран “Эерэг хандлага түгээе” сарын аян өрнүүлж, иргэд олон нийтийн цахим хаягаар мэдээлэл хүргэн ажилласан.	95	ЕБС, цэцэрлэг
40		1.2.3.1.1."Англи хэлтэй Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2025-2028	ОНТ	12.0	Судлагдахууны сургалтын чанарын гүйцэтгэлийн дундаж	46.9	51.9	3.0	“Англи хэлтэй Булган” хөтөлбөрийн хүрээнд Булган аймагт зохион байгуулсан вакумжуулсан сургалтад гадаад хэлний 4 багш хамрагдсан. Мөн IELTS-н шалгалт өгөх, сургалтад хамрагдах гэрээг Монголын англи хэлний академи тай байгуулсан. Тус гэрээний дагуу 7 хоногт 3 удаагийн цахим сургалтад гадаад хэлний багш нар хамрагдаж байна. “Xreading” цахим номын сангаас зохион байгуулдаг “Англиар уншигчдын улсын хэмжээний ганцаарчилсан марафон” 2025 оны 10 дугаар зохион байгуулагдаж, тус марафонд Дашинчилэн ЕБС-ийн “Англиар уншигчдын клуб”-ын 9 суралцагч амжилттай оролцож, аймгийн хэмжээнд 11а ангийн сурагч Г.Жавзан 10-12 дугаар ангийн төрөлд 1-р байр, 76 ангийн сурагч Б.Баясгалан 7-9 дүгээр ангийн төрөлд 1-р байр, 9а ангийн сурагч Ү.Билгүүн 7-9 дүгээр ангийн төрөлд 2-р байр, улсын хэмжээнд багш Б.Даваасүрэн 1-р байранд тус тус шалгарсан.	85.0	ЕБС
41	1.2.3.1. Засгийн газар болон дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, дэд хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлнэ.	1.2.3.1.2."Код бичих" хөтөлбөрийн хэрэгжүүлэх	2025-2028	ОНТ	4.8	Оролцогчийн тоо	36	36	1,2	"Код бичих" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг, ажлын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	40.0	ЕБС
42		1.2.3.1.3."Амжилтын гараа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	2025-2028	ОНТ	2.5	Оролцогч багийн тоо	1	1	0.5	“Амжилтын гараа” дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг Булган аймгийн бага боловсролын багш нар хамтран хэлэлцэж гаргасан. Төлөвлөгөөний дагуу 2025 оны 10 дугаар сарын 20, 21-нд хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд 11 багш, 1 сургалтын менежер хамрагдсан. Хөтөлбөрийн хүрээнд туршин хэрэгжүүлэх “Тайлбартай дасгалын” арга зүйг ашиглан 1, 2, 3 дугаар ангийн багш нар хамтран нээлттэй, үзүүлэх хичээлийг 10, 11, 12 саруудад зохион байгуулан ажиллаж байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд 2-3 дугаар ангийн сурагчдын дунд “Монгол ёс хүмүүжлийн төлөвшил олгох, өөрийгөө нээх, танин мэдэхүй, оюуны чадамжийг хөгжүүлэх, бүтээлч сэтгэлгээг дэмжих” зорилготой “АХА” тэмцээнийг зохион байгуулсан.Тэмцээнд 80 сурагч хамрагдаж, 1-р байр 3а ангийн сурагч А.Оюунзаяа, 2-р байр 2а ангийн сурагч Б.Буянбилиг, 3-р байр 3а ангийн сурагч А.Нямцэцэг нар тус тус шалгарсан байна.	85.0	ЕБС, цэцэрлэг
43		1.2.3.1.4."Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийн хэрэгжүүлэх	2025-2028	ОНТ	17.0	Оролцогчийн тоо	5	5	2.5	"Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг, ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	50.0	ЕБС
44	1.2.3.2. Сургуулийн өмнөх боловсролд шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи, уран бүтээл хийх, амьдрах ухаан, ур дүй хөгжүүлэх “STEAM” үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	1.2.3.2.1."STEAM" сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, Steam хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	2025	УТ, ОНТ	20.0	Бүлгийн тоо	2	1	5.0	2025 онд аймгийн Засаг дарга Steam хөтөлбөрийн 1 багц тоглоом, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 5.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Steam хөтөлбөрийн 1 багц тоглоомоор тус тус хангагдсан.	100.0	СӨБ

45	1.2.3.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог аймгийн дунджаас нэмэгдүүлнэ.	1.2.3.3.1.ЭЕШ-н хэмжээст оноог аймгийн дунджаас нэмэгдүүлэх	2025-2028	ОНТ	-	Хэмжээст онооны дундаж	507	520	-	2024-2025 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж 513 оноонд хүрч, аймгийн дунджаас 9 оноогоор өндөр байна.	100.0	ЕБС	
46	1.2.3.4. Жил бүр 12 дугаар анги төгсөгчдөөс суманд нэн шаардлагатай мэргэжлээр хүүхдүүдийг сургах, дэмжлэг үзүүлэх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулна.	1.2.3.4.1.Жил бүр 12 дугаар анги төгсөгчдөөс суманд нэн шаардлагатай мэргэжлээр хүүхдийг сургах, дэмжлэг үзүүлэх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулна.	2025-2028	УТ, ОНТ	20.0	Гүйцэтгэлийн хувь	0	1	5.0	2025 онд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт 12 дугаар сангийн сурагч Б.Отгондэлгэр хамрагдаж, БНСУ-д хэлний бэлтгэлд суралцаж байна.	100.0	ЕБС	
47	1.2.3.5. Бүх насны иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцахуйг дэмжин, хөгжих боломжийг бүрдүүлнэ.	1.2.3.5.1.Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох	2025-2028	УТ, ОНТ	-	Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгосон хүний тоо	суурь 2, бүрэн дунд-2	суурь 2, бүрэн дунд-2	-	Боловсрол нөхөн олгох хөтөлбөрт 2 иргэн хамрагдаж байна. Үүнээс 1 иргэн бүрэн дунд боловсрол эзэмшин 12 дугаар ангиа төгссөн. 2025-2026 оны хичээлийн жилд 2 иргэн суралцахаар хүсэлтээ ирүүлсэн байна.	90.0	ЕБС	
		1.2.3.5.2.Насан туршийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах	2025-2028	УТ, ОНТ	4.0	Хамрагдсан хүний тоо	0	20	1.0	25-45 насны иргэдийг цахим ур чадвар болон бусад цахим сургалтад хамруулсан. Шүр, тууз, давсан урлал, эко саван, эпокси сургалтуудыг зохион явуулж, 20 иргэн хамрагдсан. Шатар, даамны дугуйланг 2 ээлжээр хичээллүүлж, 30 сурагч хамрагдаж байна.	70.0	ЕБС	
БОЛОВСРОЛЫН ЗОРИЛТЫН ДУНДАЖ												85.89	
1.3. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД													
1.3.1. Гэр бүлд ээлтэй, тэгш хүртээмжтэй цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.													
48	1.3.1.1.Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлнэ.	1.3.1.1.1."Гэр бүлийн боловсрол", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" чиглэлээр сургалт зохион байгуулах	2025-2028	ОНТ	2.0	Сургалтын тоо, хамрагдсан иргэдийн хувь	2 удаагийн сургалт зохион байгуулж, 45 иргэн хамрагдсан.	30	0.5	2025 оны жилийн эцсийн байдлаар гэр бүлийн боловсрол олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 130 иргэнийг хамруулсан. Хүүхэд, Гэр бүл хөгжил хамгааллын газраас бэлтгэсэн "Гэр бүлийн боловсрол олгох" 8 модуль цуврал сургалтыг цахим хуудсуудаар дамжуулан олон нийтэд түгээн давхардсан тоогоор 928 иргэнд хүргэсэн байна. Гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн танилцуулгыг 4 багийн 124 иргэнд хүргэлээ. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны сурагчдад "Гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийлэл түүний төрлүүд" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 75 сурагч хамрагдсан.	95.0	НБМ, ХГБНА	
49		1.3.1.1.2."Гэр бүлийн боловсрол", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	2025-2028	ОНТ	2.0	Нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн хувь	2 удаагийн сургалт зохион байгуулж, 45 иргэн хамрагдсан.	10%	0.5	ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд "Гэр бүлийн хүчирхийлэл", "Утаат болон электрон тамхины хор хөнөөл, үр дагавар", "Үе тэнгийн дээрэлхэлт" сэдвийн хүрээнд Дэвжээ тэмцээнийг зохион байгуулж, 30 сурагч хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийлэл, хорт зуршил, дэлгэцийн донтолтын талаар нөлөөллийн ажлыг 3 удаа зохион байгуулж 225 сурагч хамрагдсан. Гэр бүлийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий "Авьяаслаг эцэг эхчүүд" тэмцээнийг цэцэрлэгийн 4 бүлгийн эцэг эхчүүд, сурагчдын дунд зохион байгууллаа.	95.0	НБМ, ХГБНА	
50	1.3.1.2. Гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулна.	1.3.1.2.1."Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг айл, өрхийн судалгааг гаргах, тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах	2025-2028	УТ, ОНТ	800.0	Хүчирхийлэл үйлддэг айл, өрхийн тоо	-	Бууруулна	0.2	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй гэр бүлийн судалгааг гаргасан. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг зурагт самбарыг сумын төвийн 4 цэгт байршуулсан. ХГБХХГазрын сэтгэлзүйчтэй хамтран эрсдэлт нөхцөл дэх айлуудад "Гэр бүлийн боловсрол" сургалтыг явуулын үйлчилгээгээр хүргэж, сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг 4 өрхийн 6 иргэнд хүргэсэн.	95.0	Хамтарсан баг	
51		1.3.1.2.2.Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу хариу арга хэмжээ авах	2025-2028	УТ, ОНТ	2.0	Гэр бүлийн хүчирхийллийн тоо өмнөх оноос буурсан байна.	гэр бүлийн хүчирхийллийн дуудлага-3, 108 утсанд 5 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн.	Бууруулна	0.5	2025 оны жилийн эцсийн байдлаар байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утсанд Үл хайхрах, гэр бүлийн хүчирхийллийн шинж чанартай 5 дуудлага ирсэн. Дуудлагын дагуу Хамтарсан баг нөхцөл байлын үнэлгээ хийж, шийдвэрлэн дуудлагыг хааж ажилласан байна.	100.0	НБМ, ХГБНА	

1.3.2.Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжил оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулна.

52	1.3.2.1.Хамтарсан багийг чадавхжуулах замаар хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулна.	1.3.2.1.1.Хамтарсан багийн гишүүдийн уялдаа холбоог сайжруулах, гишүүдийг чадавхижуулах, үйл ажиллагааг сайжруулах	2025-2028	УТ, ОНТ	-	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо	Хамтарсан багийн сургалтад 2 удаа хамрагдсан	2	-	Хамтарсан багийн гишүүдийг аймгийн ГХГБХХГ, МИГ даатгалтай хамтран зохион байгуулсан хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 4 удаагийн сургалт, ажлын байранд нь чадавхжуулах 1 өдрийн сургалтад тус тус хамруулсан. ХГБНАжилтныг Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан 5 хоногийн чадавхжуулах, мэргэшүүлэх сургалт, "Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүчирхийллийн хохирогч хүүхдэд өгөх анхан шатны зөвлөгөө мэдээлэл" сэдэвт 1 өдрийн сургалтад тус тус хамруулсан.	100.0	Хамтарсан баг
53	1.3.2.2. Иргэн, хувийн хэвшлийн санаачилгатай хүүхдийн хөгжил, оролцоог дэмжсэн секц дугуйлан, сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	1.3.2.2.1.Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах	2025-2028	-	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан хүүхдийн тоо	-	2, 40	-	Хар бух шагайн холбооноос ЕБС-ийн 6-10 дугаар ангийн сурагчдын дунд шагайн харвааны сургалтыг зохион байгуулсан. Шагай харваагаар 6 хүүхэд хичээллэж байна. Булган аймгийн хүүхдийн "Жаргалант" зуслангийн 2025 оны 1-7-р ээлжинд Дашинчилэн сумын сурагчид хамруулж, ирэх, очих унааны зардлыг орон нутгаас санхүүжүүлсэн. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Олон улсын Охидын эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг тусгай хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулсан. Хүүхдээ сонсох өдрийг 2025 оны байдлаар 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 119 хүүхдийг хамруулсан. Монгол Улсад "Хүүхдийн байгууллага" үүссэний 100 жилийн ойг тохиолдуулан Баярын хурал, Хүндэтгэлийн тоглолт 2025 оны 10 дугаар сард зохион байгуулж, хүүхдийн байгууллагад ажиллаж байсан ахмад багш нарт хүндэтгэл үзүүлж, дурсгалын зүйл гардуулсан.	90.0	ХГБНА, НБМ
54	1.3.2.3.Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автах аас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	1.3.2.3.1.Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автах аас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	2025-2028	УТ, ОНТ	0.4	Сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо	6 удаагийн сургалт, нлөөллийн арга хэмжээнд, 634 хүүхдийг хамруулсан.	6, 400	0.1	Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автах аас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох ажлын хүрээнд сургалт нөлөөллийн ажлыг 9 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1012 сурагч хамрагдсан байна.	95	ХГБНА, НБМ
55	1.3.2.3.Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автах аас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	1.3.2.3.2.Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автах аас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	2025-2028	УТ, ОНТ	0.8	Нөлөөллийн ажлын тоо, хамрагдсан иргэдийн тоо		4, 100	0.2	"Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй", "Охидын аминчхан уулзалт", "Хөвгүүдтэйгээ ярилцах", "Цахим гэмт хэрэг" зэрэг 4 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 580 сурагч хамрагдсан.	90	ХГБНА, НБМ

1.3.3.Залуучуудын бүх талын хөгжилд дэмжлэг үзүүлж, хөгжил оролцоог нэмэгдүүлнэ.

56	1.3.3.1. Өсвөр үе, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон, сонирхолтой өнгөрүүлэх, идэвх, оролцоог дэмжих "Залуусын хөгжил" хөтөлбөрийг сумын хэмжээнд хэрэгжүүлнэ	1.3.3.1.1."Залуусын хөгжил" хөтөлбөрийн хэрэгжүүлэх	2025-2028	ОНТ		Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	70%	0.5	"Залуусын хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Залуучуудын дунд 5 удаагийн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 268 залуучууд хамруулсан байна. 7 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, давхардсан тоогоор 824 иргэнийг хамруулан 4,994,500 төгрөгийг зарцуулсан. Олон улс болон аймгийн чанартай 2 удаагийн тэмцээн уралдаанд оролцсон 7 залууст 630,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. 12 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж, сумын нийт залуучуудын 63 хувийг хамруулсан байна. Булган аймгийн урд бүсийн залуучуудын аварга шалгаруулах спортын 3-н төрөлт тэмцээн амжилттай оролцсон. Тус тэмцээний эрэгтэй волейболын төрөлд 1-р байр, Эмэгтэй волейболын төрөлд 2-р байр, Ширээний теннис эрэгтэй төрөлд Б.Дашдаваа 3-р байр, Дартсны эмэгтэй төрөлд Болормаа 1-р байр, Шилдэг довтлогчоор А.Батмэнд, Шилдэг холбогчоор Г.Солонго нар тус тус шалгарч, багийн дүнгээр 2 дугаар байр эзэлсэн байна. Баг тамирчдын тэмцээний шатахууны зардалд 250,000 төгрөгийг олгосон. Төлөвлөгөөний хэрэгжилт 70,8 хувь байна.	85.0	НБМ, ХГБНА
57	1.3.3.2. Өсвөр үе хүүхэд залуучуудад чиглэсэн олон талт тэмцээн уралдаан, сургалт, нөлөөллийн ажлын тоог нэмэгдүүлнэ.	1.3.3.2.1.Өсвөр үе, хүүхэд залуучуудад чиглэсэн олон талт тэмцээн уралдаан зохион байгуулж, идэвхи оролцоог нэмэгдүүлэх	2025-2028	ОНТ	4.0	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан иргэдийн тоо	Тэмцээн уралдаанд 1016 хүн хамрагдаж, 9,925,000 төгрөг зарцуулсан.	1100	1.0	7 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, давхардсан тоогоор 824 иргэнийг хамруулан 4,994,500 төгрөгийг зарцуулсан.	90.0	НБМ, ХГБНА
1.3.4.Нийгмийн бүлгүүдийн хөгжил оролцоог сайжруулна.												
